Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны 10 дугаар сар)

Сөүл хот, 2026 он.

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ Х САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН . 3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 3
1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил 3
1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол 3
1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол 4
1.1.3. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ 5
1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгаллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр) 6
1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо 6
1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт 6
1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт 6

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 8
2.1. Нийгмийн хамгаллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ 8
2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд 8
2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ 8
2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр) 10

ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ 11
3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ 11
3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил 14

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ X САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны X сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.10.01 - 2026.10.30)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт 221 иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал- 37,462,590 вон, нутаг буцах зардал-4,087,320 вон болон илүү цагийн хөлс-2,630,568 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс- 6,724,700 вон, гэнэтийн ослын даатгал-29,698,634, үйлдвэрлэлийн ослын даатгал-13,747,220 зэрэг нийт 94,351,032 воныг Монгол Улсын 19 иргэнд *(давхардсан тоогоор)* олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

Иргэн Б.Х (Е-9)-гийн нутаг буцах зардал олгуулах хүсэлтийг хүлээн авч 500,000 воныг Самсунг даатгалын газраас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Б.Х (Е-9)-гийн нутаг буцах зардал, 13 дахь сарын цалинг олгуулах хүсэлтийг хүлээн авч Самсунг даатгалд хүсэлтийг илгээсэн.

Тэгүү хотын Зүүн бүсийн Хөдөлмөрийн хэлтэст (600 км) 2026.10.13-ны өдөр өргөдөл гаргагч М.Б, Н.С, Г.Г, Г.Б (визгүй) нарын олгогдоогүй цалин хөлсний

өргөдлийн мэдүүлэг өгөх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч, орчуулагчаар ажиллав.

Иргэн Л.Н-ийн (E-9) гаргасан 13 дахь сарын цалин олгуулах тухай өргөдлийг шийдвэрлэж Самсунг даатгалаас 4,433,000 воныг олгуулсан.

Иргэн Л.Г-гийн (E-9) гаргасан 13 дахь сарын цалин олгуулах тухай өргөдлийг шийдвэрлэж Самсунг даатгалаас 6,259,000 воныг олгуулсан.

Иргэн Б.Б-гийн (E-9, нас барсан) гэнэтийн ослын даатгал болох нийт 29,698,634 воныг ар гэрт нь олгуулж ажиллав.

Иргэн (E-7) Ч.Г-гийн нутаг буцах зардал 500,000 воныг Самсунг даатгалын газраас нэхэмжлэн олгуулав.

Иргэн Б.Д (E-9)-гийн нутаг буцах зардал 500,000, Самсунг даатгалын 13 дахь сарын цалин 3,353,000 нийт 4,032,030 воныг 2026.10.01-ний өдөр олгуулсан.

Хөдөлмөрийн гэрээт иргэн Б.Д (E-9)-гийн нутаг буцах зардал 537,530, Самсунг даатгалын 13 дахь сарын цалин 1 дүгээр үйлдвэр 5,015,090 вон, 2 дугаар үйлдвэр 4,077,930 вон нийт 9,630,550 воныг 2026.10.08-ны өдөр олгуулсан.

Иргэн Б.Э-гийн (E-9) 13 дахь сарын цалин 9,343,570 вон, нутаг буцах замын зардал 537,000 вон, нийт 9,880,570 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн М.М-ийн (E-9) 13 дахь сарын цалин 9,160,970 вон, нутаг буцах замын зардал 537,000 вон, нийт 9,697,970 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Э.Э-гийн (E-7-4) нутаг буцах замын зардал 525,970 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Э.С-гийн (E-9) цалин, илүү цагийн зөрүү болох 2,630,568 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Б.Х-гийн (E-9) нутаг буцах мэдэгдлийг Гүми хотын хөдөлмөрийн биржид факсаар мэдэгдэж олгуулсан.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

Иргэн Н.М-ийн (F-6) 13 дахь сарын цалин олгуулах хүсэлтийг хүлээн авч Сөүл Зүүн бүсийн Хөдөлмөрийн хэлтэст 2026.10.12-ны өдөр өргөдөл гаргагч өргөдлийн мэдүүлэг өгөх ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллав.

Иргэн Б.Г-гийн (визгүй) 13 дахь сарын цалин олгуулах хүсэлтийг хүлээн авч 고용노동부포항고용노동지청-д өргөдлийг гаргав.

Иргэн Б.Н-ийн (визгүй) үйлдвэрлэлийн осолд өртөж ажилгүй байсан үеийн цалин хөлсийг нэхэмжлэх гомдлыг 2026.06.05-ны өдөр хүлээн авч Каннам болон Чонан Хөдөлмөр халамжийн хэлтэст 15 удаагийн хүсэлтийг гарган 13,747,220 воныг олгуулсан. Гэмтлийн зэрэг тогтоогдох боломжгүй өвчин тул өвчний зэрэг тогтоолгох хүсэлтийг эмнэлгийн үйлдвэрлэлийн осол хариуцсан байцаагч хүлээн аваагүй болно.

Иргэн М.С-ийн (визгүй) нутаг буцах замын зардал болох 524,000 воныг олгуулан ажиллалаа.

Иргэн Д.Б-гийн (визгүй) сайн дураар нутаг буцах хүсэлтийг цахимаар бөглөж, илгээж ажиллалаа.

Иргэн Э.Б (D-2), М.О (D-2) нарын олгогдоогүй цалин болох 1,300,000 воныг олгуулж өргөдлийг хаалаа.

Иргэн Э.Г-гийн (визгүй) 2026.09 сарын 8, 9-ний өдрүүдэд ажилласан цалин 720,000 воныг нэхэмжилсэн өргөдлийг хүлээн авч хөдөлмөрийн хэлтэст илгээсэн.

Иргэн Н.И-гийн (визгүй) 2026.08 сард 5 өдөр ажилласан 1,314,700 воныг нэхэмжилсэн өргөдлийг хүлээн авч ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Ч.Б, Н.Т, Н.Д, Б.Т нарын (C-3) 2026.05 сараас 2026.06 сарын хооронд 17 хоног ажилласан цалингийн үлдэгдэл нийт 5,400,000 воныг олгуулахаар 안산고용노동지청 -нд өргөдөл гарган ажиллаж байна.

Иргэн Б.Х-гийн (визгүй) 2024.12.01-ний өдрөөс 18-ны өдөр хүртэл ажиллаж байх хугацаанд олгогдоогүй цалингийн үлдэгдэл болох 2,250,000 воныг олгуулахаар 목포고용노동청 -нд өргөдөл гарган ажиллаж байна.

Иргэн Г.Ц-гийн (визгүй) олгогдоогүй цалин болох нийт 4,110,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Т.Б, Л.М (G-1) нарын олгогдоогүй цалин хөлсний асуудлаар Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвд өргөдөл гарган шүүхийн шатанд шийдвэрлэгдэх явцтай байна.

Иргэн Ц.О-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлсний асуудлаар Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яаманд өргөдөл гаргасан.

Иргэн С.Б-гийн (визгүй) сайн дураар нутаг буцах хүсэлтийг цахимаар бөглөж, илгээж ажиллалаа.

1.1.3. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ

Иргэнд ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз сунгуулахад шаардлагатай оноо болон хэлний сургалтын талаар холбогдох мэдээллээр ханган ажилласан. Тус иргэнд E-7-4R виз хүсэхэд шаардлагатай бүс нутгийн талаар мэдээлэл өгсөн.

E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 1370 байна.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1. Нутаг буцах зардал	8	4,087,320
	2. Цалин, илүү цагийн хөлс	1	2,630,568
	3. Самсунгийн 13 дахь сарын цалин	6	37,462,590
	4. Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө		
	5. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6. Гэнэтийн ослын даатгал	1	29,698,634
	7. Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	1	
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9. Олгогдоогүй хойшилсон цалин хөлс	1	1,300,000
	10.13 дахь сарын цалин		
	11.Үйлдвэрлэлийн ослын даатгал	1	
	12.Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13.Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	3	5,424,700
	14.13 дахь сарын цалин		
	15.Үйлдвэрлэлийн ослын даатгал		13,747,220
	16.Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
	Нийт олгуулсан мөнгөн дүн/иргэн	**19**	**94,351,032**

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
75	16	20	24	1	41

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээний төрөл		Тоо
1.	Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	21
2.	Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	12
3.	Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлэх	10
4.	Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг	20

	олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх		
5.	Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх		3
6.	Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах		1
7.	Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах		1
8.	Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр солих болон гэнэт халагдсан тохиолдолд бүрдүүлэх материал, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлэх		1
9.	Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх		6
10.	Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн хэлтэс, Төв бирж, Эрүүл мэндийн газар, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Үндэсний тэтгэврийн алба, Хөдөлмөр, халамжийн газар (Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга)		9
11.	Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх		4
12.	Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх		
13.	Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлэх		
14.	Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах		1
15.	Визний ангилал солиулахад /E9-өөс E-7-4 виз рүү/ оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх		5
16.	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх		21
17.	Хүүхэд, гэр бүл		3
18.	Бусад мэдээлэл, зөвлөгөө		42
19.	ХурДан төрийн цахим үйлчилгээ үзүүлэх		61
Үзүүлсэн үйлчилгээний тоо		Утсаар	123
		Цахимаар	25
		Танхимаар	77
		Нийт	**221**

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.10.01 - 2026.10.30)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 15 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.
   - ❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
     - 16 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
     - 2 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
     - 11 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

   Нийт 29 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 46 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.
   - ❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
     - 20 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
     - 5 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
     - 33 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

   Нийт 58 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд

Тайлант хугацаанд тус тасаг 267,737,173.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 61 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 85,726,795.84 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 10 дугаар сард нийт 61 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 51,247,140.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 28 даатгуулагчийн 28,353,540.00 төгрөг, сайн дурын даатгалын 33 даатгуулагчийн 22,893,540.00 төгрөг байна.

2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 2026.10.14-ний өдөр БНСУ-ын Ичон хот дахь сургалтын төвд Е-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр үйлчилгээний салбарт ажиллахаар ирсэн 3 иргэнд нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас хэрхэн чөлөөлөгдөх талаар сургалт зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.
- 2026.10.22-ны өдөр БНСУ-ын Ёжу хот дахь сургалтын төвд Е-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр үйлдвэрийн салбарт ажиллахаар ирсэн 6 иргэнд даатгалд хамрагдахын ач холбогдол, холбогдох асуудлаар сургалт зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг танилцуулах, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг утсаар 318, цахимаар 15, танхимаар 20, нийт 353 иргэн, даатгуулагчид үзүүлсэн. БНСУ-д оршин сууж байгаа 26 иргэнээс нийгмийн даатгалын талаарх ойлголт, даатгалд хамрагддаг эсэх талаарх судалгаа авсан.
- 2026.10.04-ний өдөр Чонжу хотын Совон их сургуулийн талбайд зохион байгуулагдсан “Намрын фестиваль” явуулын үйлчилгээ үзүүлж, холбогдох зөвлөгөөг 5 хүнд өгч, 30 хүнд тараах материал тараасан.
- 2026.10.10-ны өдөр Ганвөн муж Ганрын хотын Гадаад иргэдийг дэмжиж төвд явуулын үйлчилгээ үзүүлж, 5 хүнд нийгмийн даатгалын талаарх зөвлөгөө мэдээлэл өгч, 20 гаруй тараах материал тарааж, 2 хүнийг сайн дурын даатгалд шинээр хамруулсан.
- 2026.10.24-ний өдөр Гванжу хотын Монгол соёлын төвийн байранд явуулын үйлчилгээ үзүүлж, 17 хүнд холбогдох зөвлөгөөг өгч, 80 хүнд нийгмийн даатгалын сурталчилгааны материал тараасан. Сайн дурын даатгалд 7 иргэнийг шинээр хамруулан ажилласан.
- 2026.10.25-ны өдөр Өмнөд Гёнсан мужийн Чанвон хотноо зохион байгуулагдсан “Олон улсын түүх, соёлын их наадам буюу MAMF” фестивальд явуулын үйлчилгээ үзүүлсэн. Нийгмийн даатгалын холбогдох зөвлөгөөг 15 хүнд өгч, 36 хүнд нийгмийн даатгалын сурталчилгааны материал тараасан. Сайн дурын даатгалд 3 иргэнийг шинээр хамруулан ажилласан.
- 2026.10.30-ны өдөр Төвийн “НЭЭЛТТЭЙ ХААЛГА” өдөрлөгийг Монгол Тауны гадна талбайд үйлчилгээ үзүүлж, холбогдох зөвлөгөөг 5 хүнд өгч, 30 хүнд сурталчилгааны материал тараасан. Сайн дурын даатгалд 1 иргэнийг шинээр хамруулан ажилласан.
- 2026.10.30-ны өдөр төвийн албан хаагчид Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, түүнтэй холбоотой бусад хуулиудын хэрэгжилтийн талаарх сургалтад хамрагдсан.
- 2026 оны III улирлын нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, журам, стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тооцоо, анхан шатны баримтын тулгалт, хяналт баталгаажуулалтыг бүрэн хийж дуусгасан. Тайланд явцын аудит хийлгэсэн.

2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ			Тоо	Өссөн дүнгээр
1.	Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	15	283
		Сайн дурын даатгал	46	413
2.	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон *(Албан журмын даатгал)*	Шинээр	11	239
		Дахин	2	28
		Хугацаа сунгасан	16	284
3.	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон *(Сайн дурын даатгал)*	Шинээр	33	238
		Дахин	5	46
		Хугацаа сунгасан	20	273
4.	Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал	87,067,200.00	975,398,000.00
		Сайн дурын даатгал	180,669,973.00	1,754,944,859.01
		Нийт	267,737,173.00	2,730,342,859.01
5.	Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	28,353,540.00	287,293,468.00
		Сайн дур	22,893,540.00	220,620,171.00
6.	БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт	Нэхэмжилсэн	10,886,400,00	162,912,470.00
		Олгосон	0	131,253,410.00
		Буцаан олголт авсан хүний тоо	2	30
7.	Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	318	3,345
		Цахимаар	15	232
		Танхимаар	20	555

ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ


Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 21, youtube сувагт 1, байгууллагын seoulcenter.mlsp.gov.mn цахим хуудсанд 21 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилж, 81,244 иргэн мэдээлэл авахаар хандаж, 52 удаа мэдээ мэдээллийг хуваалцсан байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээт иргэдэд ирсний дараах танхимын 3 сургалтыг нийт 38 иргэнд (2026.10.01-ний өдөр Ёжү хотод үйлчилгээний салбарт ажиллахаар ирсэн 29 иргэнд, 2026.10.15-ны өдөр Ичон хотод 3 иргэнд, 2026.10.21-ний өдөр Ёжү хотод 6 иргэнд) зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл
- Ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.





Ёжу хотод зохион байгуулагдсан сургалтын үеэр



Ичон хотод зохион байгуулагдсан сургалтын үеэр

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хөдөлмөрийн харилцаанд тулгарч байгаа асуудал, мөн ажлын байр солих, ур чадвартай ажиллах хүчний Е7-4 визний талаар мэдээлэл, зөвлөгөө өгч цахим уулзалтыг 2026.10.21-ний өдөр зохион байгуулж 22 иргэд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.





Цахим мэдээлэл, зөвлөгөө

Тайлант хугацаанд нийт 7 удаагийн явуулын үйлчилгээгээр 144 иргэнд хөдөлмөрийн харилцаанд холбогдох зөвлөгөө мэдээлэл хүргэж ажиллав.Тухайлбал:

2026.10.04-ний Ням гарагт Чонжү хотод зохион байгуулагдсан “Намрын фестиваль” арга хэмжээнд хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөвлөгөө, мэдээллийг 20 иргэнд, Төвийн үйл ажиллагааг 65 иргэнд танилцуулж, материал тарааж ажилласан.





Чонжү хотод зохион байгуулагдсан зөвлөгөө мэдээллийн үеэр

2026.10.10-ны өдөр БНСУ-ын Канвон аймгийн Канрын хотод зохион байгуулагдсан Консулын явуулын үйлчилгээнд оролцож, иргэдэд төвийн үйл ажиллагааг сурталчлан, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалтай холбоотой зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.




Канрын хотод зохион байгуулагдсан зөвлөгөө мэдээллийн үеэр

“Хариуцлагатай амьдарцгаая” аяны хүрээнд Монголаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамтай хамтран оюутан, залууст зориулсан “Гадаад оронд хэрхэн хурдан дасан зохицох вэ” сэдэвт сэтгэлзүйн зөвлөгөө, сургалтыг 2026.10.14-ний өдөр Хангон их сургуулийн 40 гаруй, 2026.10.15-ны өдөр Хансө их сургуулийн 20 гаруй оюутан, нийт 60 гаруй оюутан, залууст зохион байгуулж ажиллав. Сургалтын үеэр гадаад оронд суралцаж, амьдарч буй оюутан, залууст түгээмэл тулгардаг соёлын ялгаа, хэлний бэрхшээл, ганцаардал, стресс, сэтгэл түгшилт зэрэг сэтгэлзүйн сорилтыг даван туулах арга замын талаар бодит жишээ, практик зөвлөмж хүргэлээ. Мөн шинэ орчинд дасан зохицох, сэтгэлзүйн тогтвортой байдлаа хадгалах, тулгарч буй бэрхшээлийг зөвөөр даван туулах мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа. Энэхүү сургалт нь БНСУ-д суралцаж, амьдарч буй Монголын оюутан, залуусын сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжих, гадаад орчинд дасан зохицох чадварыг бэхжүүлэх, сэтгэлзүйн тулгамдсан асуудлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт боллоо.




Сосан хотод зохион байгуулагдсан ”Хариуцлагатай амьдарцгаая” аян

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн албан хаагчид 2026.10.24-ний өдөр Гуанжу хотын Солонгос Улс дахь Монгол соёлын төвийн байранд иргэдэд хөдөлмөрийн харилцаа, Монгол Улсын нийгмийн даатгалын талаарх зөвлөгөө мэдээллийг 80 гаруй иргэнд өгөв.





Гуанжу хотод зохион байгуулагдсан зөвлөгөө мэдээллийн үеэр

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн албан хаагчид 2026.10.25-ны өдөр Чанвон хотод зохион байгуулагдсан “МАМФ” олон үндэстний наадамд иргэдэд хөдөлмөрийн харилцаа, Монгол Улсын нийгмийн даатгалын талаарх зөвлөгөө мэдээллийг 36 иргэнд өгч ажиллав.






Чанвон хотод зохион байгуулагдсан “МАМФ” олон үндэстний наадмын үеэр

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2026.10.30-ны өдөр Монгол Тауны гадна талбайд зохион байгуулж нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцаатай холбогдох асуудлаар иргэдэд зөвлөгөө өгч ажилласнаас гадна иргэд “Whte E” шүдний эмнэлгийн үзлэг, зөвлөгөө, "Апгужон” нүдний эмнэлэг, “Чадунсог” виз мэдүүлгийн төвөөс визийн талаарх зөвлөгөө, мэдээллийг өглөө.




Монгол тауны гадна талбайд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийн үеэр

3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь 2026.10.07-ны өдөр БНСУ-ын Апгужон нүдний эмнэлэгтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдэд нүдний эмнэлгийн үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр, үр ашигтай үзүүлэх боломжийг бүрдүүллээ. Тус санамж бичгийн хүрээнд иргэд эмнэлгээс тогтоосон нүдний иж бүрэн үзлэгийн үндсэн багцад багтах шинжилгээг үнэ төлбөргүй хийлгэх, нүдний мэс засал шаардлагатай гэж тогтоогдсон иргэд мэс заслын төлбөрт тусгай хөнгөлөлт эдлэх боломжтой байна.




Апгужон нүдний эмнэлэгтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах үеэр

Албан хаагчид Монгол таунд хуваарийн дагуу ээлжээр ажиллаж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай тогтмол эргэх холбоотой ажиллах зорилтын хүрээнд 24 иргэнтэй утсаар холбогдож, нөхцөл байдлыг нь тодруулж, хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- - - oOo - - -